“9¹.3.1. урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч төсвийн алдагдал баталсан хэмжээнээс дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиар нэмж буурсан тохиолдолд үнэ болон биет хэмжээ нь төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн Төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;”

2/17¹ дүгээр зүйлийн 17¹.1 дэх хэсэг:



“17¹.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өмнөх онд төвлөрүүлсэн орлого, санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл болон жилийн эцсийн үлдэгдлийг харгалзан Олон улсын хамтын ажиллагааны сангийн хөрөнгийн хэмжээг тооцож төлөвлөнө.”

3/26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг:

“26.3.Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд энэ хуулийн 6.4.6, 6.4.10-т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно.”

4/26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг:

“26.6.Энэ хуулийн 5.4.3-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах журмыг Засгийн газар батална.”

5/29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт:

“29.1.1.энэ хуулийн 5.4.2, 5.4.4, 5.4.6, 5.4.8, 5.4.12-5.4.14, 5.4.16, 5.4.20, 5.4.25, 5.4.29, 5.4.30, 5.4.32, 5.4.33-т заасан тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг энэ хуулийн 26.3-т заасан этгээдийн шийдвэрээр;”

3 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтын “5.4.3, 5.4.19-д” гэснийг “5.4.3-т” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 5.4.5, 5.4.17, 5.4.19, 5.4.21-5.4.23, 5.4.26, 5.4.31, 5.4.34, 5.4.35 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2.9, 6.4.1, 6.4.3, 6.4.8, 6.4.9, 6.4.11, 6.4.12, 6.4.14, 6.4.17, 6.4.18, 6.4.20, 6.5.4 дэх заалт, 11, 13, 18, 19, 21, 21¹, 21², 21⁴, 21⁶, 25, 25² дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.2, 30.7 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Инновацийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10.3 дахь заалтын “Инновацийн санд” гэснийг “улсын төсөвт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.2, 17.1.9, 17.1.10 дахь заалтын “Инновацийн сангаас” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Инновацийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Агентлаг нэгээс илүүгүй орлогч даргатай байна. Агентлагийн орлогч даргыг төрийн албаны төв байгууллагын дүгнэлтийг харгалзан Монгол Улсын сайд томилж, чөлөөлнө.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “Тэргүүлэгчид өөрөө тогтооно” гэсний өмнө “Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалт:

“30.1.2.аймгийн Засаг дарга нэгээс илүүгүй, нийслэлийн Засаг дарга хоёроос илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;”

2/31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт:

“31.1.2.сум, дүүргийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байх бөгөөд орлогчийг тухайн Хурлын Тэргүүлэгчидтэй зөвшилцөн томилох, чөлөөлөх;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “өөрийн ажлын хэсэг,” гэснийг хассугай.



2 дугаар зүйл.Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ
ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын тухай хуулийн 26¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.5.3, 13.5.4 дэх заалт:

“13.5.3.хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;



13.5.4.нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;”

2/29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг:

“29.2.Энэ хуулийн 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг:

“6.1.Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т заасан бараа болон эх орны үйлдвэрийн автобензин, дизелийн түлшний тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл		Биет нэгж	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/	
				Эх орны үйлдвэрийн бараа	Импортоор авсан бараа
1	Хүнсний зориулалттай спирт	согтууруулах ундааны болон эмийн үйлдвэр, хүн, мал эмнэлгийн хэрэгцээнд худалдсан	1 литр	1450	-



		бусад газарт худалдсан	1 литр	14500		-
2	Бүх төрлийн архи	25 хүртэл хатуулагтай	1 литр	аймагт 2900	нийслэлд 2900	7250
		25-40 хүртэл хатуулагтай	1 литр	5800	5800	14500
		40 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	13050	13050	17400
		Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан шимийн архи	1 литр	290		-
4	Бүх төрлийн дарс	35 хүртэл хатуулагтай	1 литр	725		2175
		35 ба түүнээс дээш хатуулагтай	1 литр	6525		8700
5	Бүх төрлийн пиво		1 литр	290		290
6	Янжуур болон түүнтэй адилтгах бусад тамхи		100 ширхэг	3480		3480
7	Дүнсэн болон түүнтэй адилтгах задгай тамхи		1 килограмм	2610		2610
8	Автобензин	90 хүртэл октантай	1 тонн	0-15950		-
		90 ба түүнээс дээш октантай	1 тонн	0-17400		-
9	Дизелийн түлш		1 тонн	0-21750		-

“

2/6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэг:

“6.3.Энэ хуулийн 4.1.4-т заасан суудлын автомашин импортолсон бол үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзан дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:



Д/д	Хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж /см³/	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
		Үйлдвэрлэгдсэн оноос хойших хугацаа /жилээр/			
		0-3 жил	4-6 жил	7-9 жил	10 ба түүнээс дээш жил
1	1500 ба түүнээс доош	725000	1450000	2900000	8700000
2	1501-2500	2175000	2900000	4350000	10150000
3	2501-3500	2900000	3625000	5800000	11600000
4	3501-4500	6525000	7250000	9425000	15225000
5	4501 ба түүнээс дээш	10150000	10875000	13050000	18850000

6.4.Энэ хуулийн 4.2-т заасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжид дараах хэмжээгээр онцгой албан татвар ногдуулна:

Д/д	Онцгой албан татвар ногдуулах барааны нэр, төрөл	Биет нэгжид ногдуулах онцгой албан татварын хэмжээ /төгрөгөөр, сард/
1	Тоглоомын ширээ буюу электрон хүрд	116000000
2	Автомат тоглоом	4350000
3	Тоглоомын үр дүнг харуулсан касс буюу тотализатор	116000000
4	Бооцоо тооцоолох букмейкерийн төв	116000000

2 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “25000 америк доллартай” гэснийг “36250000 төгрөгтэй” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Орон сууцны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Орон сууц хөгжүүлэх сан,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Орон сууцны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалт, мөн хуулийн 11.2, 11.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Өрсөлдөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Прокурорын байгууллагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Үндэсний статистикийн хороо Дэд даргатай байна. Дэд даргыг Үндэсний статистикийн хорооны дарга томилно.”

2 дугаар зүйл.Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “тэдний” гэснийг “түүний” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Тэргүүн дэд болон” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2 дахь заалтын “Сэргээгдэх эрчим хүчний сангаас” гэснийг “Засгийн газраас” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн Тавдугаар бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“30.2.Энэ хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчид үндсэн цалингийн дунджаас нь ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “түүний орлогч,” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.13 дахь хэсгийн “Төрийн албаны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгааны болон зөвлөх үйлчилгээний нэгжтэй байж болно.” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“11.1.4.байгаль орчин, хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“29.2.Төрийн өмчийн эрүүл мэндийн болон боловсролын байгууллагад 25 ба түүнээс дээш жил, өрхийн эрүүл мэндийн төв, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтан тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас тооцуулан ажиллаж байгаа байгууллагаасаа авах эрхтэй. Нэг удаагийн тэтгэмж тооцох цалингийн дундаж хэмжээ, тэтгэмж олгох шалгуур нөхцөлийг Төрийн албаны тухай хуулийн 30.2-т заасан журмыг баримтлан тогтооно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

“Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2015 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

**Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хэлэлцэх боломжгүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/Монгол Улсын төсвийн 2008-2014 онуудын хөрөнгө оруулалтад тусган бүрэн хэрэгжүүлж дууссан, гэрээний үлдэгдэл санхүүжилт бүхий, хавсралтад заасан төсөл, арга хэмжээг векселиэр санхүүжүүлэх арга хэмжээг авч, Монгол Улсын 2016 оны төсөвт тусгах;

2/Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд заасан, бодит гүйцэтгэл нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 80-аас дээш хувьтай хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг векселиэр санхүүжүүлэх арга хэмжээг авч, Монгол Улсын 2016 оны төсөвт тусгах;

3/Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд заасан боловч тендер шалгаруулалт зарлагдаагүй, хэрэгжиж эхлээгүй төсөл, арга хэмжээг хасах, гүйцэтгэл нь удааширсан төсөл, арга хэмжээг хянасны үндсэн дээр зориулалтын дагуу үргэлжлүүлэх, эсхүл дуудлага худалдаанд оруулах арга хэмжээг авах;

4/төрийн улс төрийн албан тушаалтны зарим урсгал зардлыг 5 хувь бууруулж байгаатай холбогдуулан тухайн зардлын норм, нормативыг тогтоосон Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэрт өөрчлөлт оруулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Болор/-нд, энэ тогтоолын хэрэгжилтийг Төсвийн байнгын хороонд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т тус тус даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
07 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН 2008-2014 ОНУУДЫН ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТАД ТУСГАН БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ ДУУССАН,
ГЭРЭЭНИЙ ҮЛДЭГДЭЛ САНХҮҮЖИЛТ БҮХИЙ, ВЕКСЕЛИЭР
САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/сая төгрөгөөр/

Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2015 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Аймгийн прокурорын газрын конторын барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2013	2015	1,000.0	276.0
2	Улсын ерөнхий прокурорын газрын компьютер, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2013	2015	159.0	159.0
3	Аврах гал унтраах ангийн барилга /Ховд, Булган сум/	2011	2015	1,022.4	182.7
4	Зорчигчийн биед үзлэг хийх рентген төхөөрөмж, 2 ширхэг /Улаанбаатар, Дорноговь/	2013	2015	578.9	578.9
5	Тосгоны нэгдсэн халаалтын системийн барилгын ажил /Булган, Хангал сум, Хялганат/	2012	2015	634.3	63.7
6	Газрын тос боловсруулах үйлдвэрийн гол дэд бүтэц, техник, эдийн засгийн үндэслэл, зураг /Дархан-Уул, Дархан сум/	2013	2015	289.6	176.0
7	Аймгийн төвд шинээр баригдаж байгаа орон сууцны барилгуудын гадна инженерийн шугам сүлжээний ажил /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	2015	400.0	400.0



8	Монгол орны 1:100000 масштабтай хөрс, ургамлын зураг болон холбогдох мэдээллийг нэгдсэн арга зүй, стандартын дагуу нэгтгэж тоон хэлбэрт оруулах, мэдээллийн сан байгуулах /Улсын хэмжээнд/	2014	2015	607.0	607.0
9	Монгол Улсын аймаг, сумын төвийн 1:1000 масштабтай байр зүйн зургийг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, мэдээллийн сан байгуулах /Улсын хэмжээнд/	2014	2015	178.5	178.5
10	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2011	2015	650.0	67.7
11	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Гурвансайхан сум/	2011	2015	550.0	15.3
12	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 12 дугаар цэцэрлэг/	2011	2015	935.3	284.8
13	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 6 дугаар хороо/	2011	2015	589.8	39.8
14	Сургуулийн барилга, 928 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	2011	2015	2,743.3	50.0
15	Сургуулийн барилгын өргөтгөл, 520 суудал /Увс, Улаангом сум, Шинэ-Ирээдүй/	2011	2015	2,100.0	41.1
16	Сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 70 дугаар тусгай сургууль/	2011	2015	1,295.0	51.9
17	“Эрдмийн ундраа” цогцолбор сургуулийн барилгыг 3 давхар болгон өөрчлөх /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 54, 77, 78 дугаар сургуулиуд/	2012	2015	2,900.0	286.9
18	Сургуулийн барилгын өргөтгөл /Булган, Хангал сум, Хялганат/	2011	2015	1,964.0	50.7
19	Сургуулийн барилгын үлдэгдэл санхүүжилт, 320 суудал /Ховд, Булган сум/	2012	2015	1,860.0	360.0
20	Сургуулийн барилга, спорт заал /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2010	2015	3,440.0	500.0
21	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 92 дугаар сургууль/	2011	2015	3,293.8	543.8
22	Сургууль, цэцэрлэг /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	2015	1,380.0	140.5



23	Спорт заалын барилга /Дорнод, Хэрлэн, 6 дугаар сургууль/	2012	2015	938.3	107.2
24	1,3-10 дугаар багийн спорт талбай байгуулах /Дорнод, Хэрлэн сум, Хивсний, Нуурын, Цэнхэр хороолол/	2012	2015	932.4	46.7
25	“Оюутны байр-1000” хөтөлбөрийн хүрээнд 1000 оюутны байр “Б блок” байрын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар/	2011	2015	6,950.0	142.5
26	Сургуулийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн 2 дугаар байр/	2012	2015	1,970.3	270.3
27	Сансар судлалын музей, планетариумын барилга /Улаанбаатар/	2008	2015	1,001.3	112.1
28	Нисэх буудал чиглэлийн хатуу хучилттай авто зам /Дорнод, Хэрлэн/	2013	2015	1,950.0	32.0
29	Сайншанд-Хамрын хийд чиглэлийн 42 км хатуу хучилттай авто зам /Дорноговь/	2011	2015	17,632.8	1,663.2
30	Өлгий-Цагааннуур чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий/	2009	2015	13,295.0	830.7
31	Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.5 км хатуу хучилттай авто зам /Завхан/	2011	2015	10,300.0	439.9
32	Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км авто замын шинэчлэл /Улаанбаатар/	2012	2015	12,790.4	948.5
33	Налайх-Агуйтын хөтөл чиглэлийн 24.1 км замын шинэчлэл /Улаанбаатар/	2012	2015	8,280.0	501.4
34	Налайх /4 дүгээр зөрлөг/- Зуунмод чиглэлд 25 км хатуу хучилттай авто зам /Улаанбаатар/	2012	2015	13,109.4	1,315.1
35	Мөрөн-Хатгалын 98.8 км хатуу хучилттай авто зам /Хөвсгөл, Хатгал сум/	2008	2015	19,371.1	818.9
36	Дархан-Сүхбаатар чиглэлийн авто замаас Орхон сумын төв хүртэлх 8.23 км хатуу хучилттай авто зам /Дархан-Уул/	2012	2015	2,586.4	194.8



37	Арвайхээр - Баянхонгор чиглэлийн 107 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл болох 1.3 км авто зам /Өвөрхангай/	2013	2015	474.5	86.2
38	Хархорин, Хужирт сумын төвд тус бүр 1 км хатуу хучилттай авто зам барих /Өвөрхангай/	2011	2015	720.0	19.2
39	Баянхонгор-Нарийнтээл чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл санхүүжилт	2013	2015	3,102.5	17.3
40	Аймгийн төвийн авто зам засвар /Дорнод, Хэрлэн/	2012	2015	1,220.0	114.0
41	2 км авто зам /Булган, Булган, 1 дүгээр баг/	2012	2015	846.9	38.8
42	Авто замын шинэчлэл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	2015	1,584.9	177.6
43	Хорооллын доторх барилга, засвар, авто зам, хот тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2012	2015	700.0	0.8
44	Баянбүрдийн тойргоос 32 тойрог хүртэлх 1.7 км авто замын шинэчлэлт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 9-11 дүгээр хороо/	2013	2015	2,490.7	83.5
45	Бэлхийн шинээр баригдсан 5 км авто замын үргэлжлэл болох 0.7 км авто замыг шинээр барих, нийт 5.7 км авто замын нийт уртад гэрэлтүүлэг хийх /Улаанбаатар/	2013	2015	1,701.2	12.8
46	Доржийн гудамж, Туул жин пангийн уулзвараас зүүн тийш - Цайз зах хүртэлх 2.8 км авто замын өргөтгөл шинэчлэлт /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 22 дугаар хороо/	2012	2015	5,700.0	73.4
47	39 дүгээр сургуулийн зүүн урд талын уулзвараас Хүчит шонхор зах-эцсийн буудал хүртэлх 1.6 км авто замын өргөтгөл шинэчлэлт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 11 дүгээр хороо/	2013	2015	1,350.0	15.2
48	Бэлхийн 5 км авто замын шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2012	2015	2,810.0	2.1
49	Сумын төвийн доторх 3 км замыг хатуу хучилттай болгох /Завхан, Тосонцэнгэл сум/	2012	2015	1,920.0	178.0



50	Аймгийн төвийн авто зам шинэчлэл /Ховд/	2012	2015	3,000.0	332.7
51	Тамирын голын бетон гүүр /Архангай, Батцэнгэл сум/	2012	2015	3,885.5	243.8
52	Тээлийн голын 75 у/м төмөр бетонон гүүр /Увс/	2011	2015	799.0	13.7
53	Нарийний голын 325 у/м төмөр бетон гүүр /Увс, Тэс/	2011	2015	5,380.2	64.2
54	Орхон голын 235.2 у/м төмөр бетон гүүр /Сэлэнгэ, Хушаат/	2011	2015	3,750.0	304.6
55	Тэсийн голын 240.26 у/м төмөр бетон гүүр /Завхан, Тэс/	2012	2015	3,800.0	276.3
56	Туул голын модон гүүрийн засвар /Төв, Алтанбулаг/	2013	2015	100.0	22.8
57	Ховд голын 186 у/м төмөр бетон гүүрийн их засвар /Баян-Өлгий/	2013	2015	1,116.0	291.3
58	Улсын чанартай авто зам, гүүрний засвар, арчлалт, шинэчлэлт /2013 оны үлдэгдэл/ /улсын хэмжээнд/	2014	2015	370.3	20.4
59	Нийслэл хотоос орж, гарч байгаа авто замын тээврийн хяналтын цэгүүд дээр авто пүү суурилуулах	2012	2015	600.0	6.4
60	Хүүхдийн номын сангийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум/	2011	2015	968.4	142.0
61	Соёл, урлагийн заал /Дорнод, Баянтүмэн сум/	2012	2015	1,023.4	213.4
62	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн барилга, 640 суудал /Завхан, Улиастай сум/	2012	2015	3,220.7	345.3
63	Алтанбулагийн чөлөөт бүсийн Сүхбаатар-Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолойн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2012	2015	7,220.0	1,203.0
64	Алтанбулагийн чөлөөт бүсийн Сүхбаатар-Сэлэнгийн 25 км бохир усны шугам хоолойн ажлын цахилгаан хангамжийн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2012	2015	1,379.8	187.3
65	Алтанбулагийн чөлөөт бүсийн гааль, худалдааны зам талбайн ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2012	2015	986.5	245.5



66	Алтанбулагийн чөлөөт бүсийн үерийн хамгаалалтын далан суваг /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2011	2015	6,290.2	2,005.0
67	Бүсийн хүзүүвчний хэсгийн дутуу баригдсан тусгаарлах хашааны угсралтын ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2008	2015	112.8	82.8
68	“Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн гааль, худалдааны талбай дахь мэргэжлийн албадын байр, гаалийн агуулахын сендвичэн барилгын дутуу баригдсан барилгын ажил /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2009	2015	688.0	688.0
69	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /Өвөрхангай, Арвайхээр сум/	2011	2015	1,795.7	441.4
70	Эрүүл мэндийг дэмжих төв /Орхон, Баян-Өндөр сум/	2011	2015	1,103.8	369.8
71	Хүүхдийн цусны төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2015	616.5	216.5
72	Эмнэлгийн барилга, 20 ор /Сүхбаатар, Онгон сум/	2011	2015	815.5	198.6
73	Төрөх эмнэлэг, 50 ор /Завхан, Улиастай сум/	2011	2015	2,179.2	131.0
74	Эмнэлгийн барилга, 10 ор /Говь-Алтай, Дэлгэр сум/	2012	2015	736.6	41.3
75	Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Улаанбаатар/	2013	2015	8,100.0	451.5
76	Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	2013	2015	6,880.0	498.4
77	Баянлиг-Шинэжинст сумын 35 кВ-ын 135 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Баянхонгор/	2012	2015	4,373.0	1,001.9
78	Малчин-Тэс сумын 35 кВ-ын 115 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, шугамын ажлыг эхлүүлэх /Увс/	2012	2015	3,500.0	637.9



79	Дархан хотын 110/6 кВ-ын Давхар дэд станцын 110 кВ-ын ил, 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх /Дархан-Уул/	2012	2015	2,381.1	217.7
80	Халиун-Цээл сумын 35 кВ-ын 31.4 км, 15 кВ-ын 84.5 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Говь-Алтай/	2012	2015	2,214.0	1,104.0
81	6 кВ-ын кабелийн шинэчлэл, газар доорх кабелийн гэмтэл илрүүлэх багаж авах /Баян-Өлгий/	2012	2015	450.0	250.0
82	Тайширын усан цахилгаан станцын ажиллагсдын орон сууц, конторын барилга, халаалтын зуухны хамт /Говь-Алтай, Тайшир сум/	2011	2015	801.7	228.7
83	Сумдын 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын иж бүрэн шинэчлэл /Улсын хэмжээнд/	2012	2015	5,000.0	380.7
84	Дулааны цахилгаан станц 2-ын цахилгаан тоноглолын шинэчлэл /Улаанбаатар/	2013	2015	2,194.5	232.0
85	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2010	2015	13,000.0	800.0
86	Дулааны цахилгаан станц 2-ын зуухны шинэчлэл /Улаанбаатар/	2011	2015	3,000.0	316.5
87	НС-3-ын насосуудыг хувьсах хурдны насосуудаар шинэчлэх /Улаанбаатар/	2012	2015	2,805.1	126.1
88	Дулааны цахилгаан станц 2-ын ПТ-12-35 турбины тохируулгын блок сольж шинэчлэх /Улаанбаатар/	2013	2015	500.0	350.0
89	Дулааны цахилгаан станцын 12 МВт-ын турбины тохируулгын блок, тулах холхивчуудын шинэчлэл /Дархан Уул, Дархан/	2013	2015	550.0	400.0
90	Дулааны станцын К1, К2 зуухны засвар, шинэчлэлт /Дархан-Уул, Шарын гол/	2013	2015	465.3	64.5
91	Дулааны цахилгаан станц 2-ын ТС-35-39 зуух №1, 3-т үнс барих цахилгаан шүүлтүүр суурилуулах /Улаанбаатар/	2013	2015	1,000.0	736.1
92	"Дулааны цахилгаан станц 4" ТӨХК-д зуухнуудын үнс, утааны хийн ялгаруулалтыг бууруулах технологи нэвтрүүлэх /Улаанбаатар/	2012	2015	5,000.0	833.6



93	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан/	2011	2015	5,000.0	2,000.0
94	Дэлхийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа “Эрчим хүчний төслийн нэмэлт санхүүжилт” төслийн дотоод эх үүсвэр	2010	2015	6,400.0	522.3
95	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Улиастайн шугам сүлжээний төсөл”-ийн монголын талын хөрөнгө /Завхан, Улиастай/	2010	2015	800.0	100.8
96	Дулааны цахилгаан станц, станцын горим, үндсэн ба туслах тоноглолын ашиглалтын лабораторыг шинээр байгуулах /Улаанбаатар/	2013	2015	560.0	300.0
НИЙТ				291,211.8	32,936.1

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүний хөгжил сангийн төсвийн цаг зуурын хүндрэлийг даван туулахад зориулан 461,120.8 сая төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг 2015 оны төсвийн жилд гаргаж, арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 01 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1/нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын цахилгаан эрчим хүчний үнэд хөнгөлөлт үзүүлэх урамшууллын шалгуур, хэлбэр, цаг, хувь хэмжээг тогтоож, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх;”

2.Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2015 оны 01 дүгээр
сарын 28-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд



П.Очирбат, Т.Лхагваа, Ш.Цогтоо/илтгэгч/, Д.Ганзориг нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч Монгол Улсын иргэн Ц.Чулуунтогтох, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан нар оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 хорооны оршин суугч, иргэн Ц.Чулуунтогтох Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлд: 55.1 дэх хэсэгт Төлбөр төлөгч-иргэний зайлшгүй хэрэгцээт дараахь эд хөрөнгийг төлбөрт хураан авч болохгүй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтад “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас” гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “...Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;” хэмээснийг зөрчиж байна. ...

Бусдын өмнөөс хариуцлага хүлээх нь Ардчилсан биш нийгмийн тогтолцооны үндэс болно. Боолын, Феодалын, Коммунист нийгэмд тийм зүйлийг хүлээн зөвшөөрдөг байж магадгүй. Иймд энэхүү асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Мэдээлэл гаргагч иргэн Ц.Чулуунтогтох Үндсэн хуулийн цэцэд гаргасан нэмэлт тайлбартаа:

“НЭГДҮГЭЭРТ. Төлбөр төлөгчийн талаарх ойлголтыг авч үзье.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт “Төлбөр төлөгч гэж төлбөр авагчийн эрх, эрх чөлөө,



хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.”

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт Гүйцэтгэх баримт бичгийн талаар тодорхойлсон байх бөгөөд иргэний ба эрүүгийн болон бусад хэрэг маргааны талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг багтаан ойлгохоор байна.

Дүгнэвэл: Төлбөр төлөгч нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу өөрийн учруулсан гэм буруугийн төлөө хариуцлага хүлээн, хохирлыг арилган төлбөр төлөх үүрэг хүлээж байгаа иргэн, хуулийн этгээд болно.

ХОЁРДУГААРТ. Гэм буруутны ял зэмлэлийн талаарх ойлголтыг авч үзье.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “... Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно...” хэмээн заасан.

1. Гэм буруутан хэмээх ойлголт нь Эрүүгийн болон Иргэний хуульд аль алинд нь тодорхой заасан байна. Зөвхөн түүнтэй хариуцлага тооцох талаар ч заажээ.

2. Ял хэмээх ойлголтыг Эрүүгийн хуульд зааснаар ойлгох нь тодорхой байна. Гэм буруутай тухайн этгээдэд өөрт нь ногдуулна.

3. Эрүү, Иргэн, Захиргааны хариуцлагын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад “зэмлэл” хэмээх ойлголт байхгүй байна. Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “шийтгэвэр, буруушаалт, донгодлого, арга хэмжээ” хэмээн тодорхойлжээ. Энэхүү тайлбар хэсгийг хавсаргав.

Дүгнэвэл: “ял зэмлэл” хэмээх ойлголт нь гэм буруутай этгээдэд ногдуулж байгаа албадлагын арга хэмжээг тодорхойлж байна.

ГУРАВДУГААРТ. Нэгтгэн дүгнэж үзье.

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу төлбөр төлөх үүрэг хүлээсэн этгээдийн өмнөөс гэр бүлийн гишүүд, хамаатан саданд нь давхар үүрэг хүлээлгэх нь шударга ёсны зарчимд харшилж байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйл 55.1.2 дахь заалтыг хэрэгжүүлбэл гэр бүлийн гишүүдийнх нь өмч, хөрөнгө болох хувцасыг буруутны төлбөрт шударга бусаар хураагаад зогсохгүй, өмссөн нэг ээлжийн хувцастай нь үлдээж, гэм буруугүй этгээдийг хэлмэгдүүлэх үйлдэл юм.

Түүхэнд гарч байсан өмч хөрөнгө хураах, нэгдэл коммунд хүчээр нэгтгэсэн зэрэг хэлмэгдлийн шинж чанартай үйл явдлыг дахин давтах бололцоог олгож байна.

Хэлмэгдүүлэлтийн хор уршиг хэзээ ч арилдаггүй, хувь хүн түүний гэр бүлийн амьдралд үеийн үед үл арилах хорт уршиг үлдээдэг билээ. Иймд үүнийг таслан зогсоох шаардлагатай байна.” гэжээ.

Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газраас 2014 оны 11 дүгээр сарын сарын 11-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь хэсэгт “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас”-ыг төлбөрт хурааж болохгүй эд хөрөнгө гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчсөн талаар иргэний өргөдөлд дурджээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 онд шинэчлэн батлагдсанаас хойш 279847 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулан явуулсан.

Хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс өнөөг хүртэлх хугацаанд шүүхийн шийдвэрт заасан мөнгөн төлбөрийг гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний хувцсыг төлбөрт хураах ажиллагаа явагдаагүй болно.

Учир нь иргэний хэрэглэж байсан хувцас төлбөрийн шаардлага хангахгүй, худалдан борлуулах боломжгүй эд хөрөнгө байдаг бөгөөд төлбөр авагчдын зүгээс шүүхийн шийдвэрт заасан төлбөрийг мөнгөн хэлбэрээр гаргуулах хүсэлтэй, бусдын эдэлж, хэрэглэж байсан эд зүйлийг төлбөрт тооцон авахаас эрс татгалздаг тул шийдвэр гүйцэтгэх



ажиллагаагаар төлбөр төлөгчийн гэр бүлийн гишүүдийн хуулиар олгогдсон эрхийг хөндөх, хязгаарлах үйл ажиллагаа явагдаагүй байна.

Сүүлийн 5 жилд явагдсан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үзүүлэлтээс харахад улсын хэмжээнд нийт 2.3 тэрбум төгрөгийн 127632 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж, үүнээс 1.0 тэрбум төгрөгийн 70848 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлж, гүйцэтгэлийн хувийн хэргийг хаасан.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар нийт гүйцэтгэх баримт бичгийн 95.2 хувь нь мөнгөн хэлбэрээр, 0.7 хувь үл хөдлөх эд хөрөнгөөр, 3.1 хувь нь хөдлөх эд хөрөнгө, 1.0 хувь нь мөнгөн төлбөрийн үүрэг ногдуулаагүй шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн байна. ...

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр төлөгч, төлбөр авагч, бусад этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх зарчимд тулгуурлан явагддаг, ялангуяа ажиллагааны явцад гуравдагч этгээдийн эрх хөндөгдсөн тохиолдолд шүүхэд гомдол гаргах, хөндөгдсөн эрхээ сэргээх боломжийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар олгосон болно.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтад “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас”-ыг төлбөрт хураан авч болохгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “...Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно. ...” гэснийг зөрчөөгүй гэж үзэж дараах үндэслэлийг гаргаж байна:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “Төлбөрийг төлбөр төлөгч-иргэний өмчлөлийн эд хөрөнгө болох түүний банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаас, түүнчлэн үл



хөдлөх ба хөдлөх эд хөрөнгө, бусад хөрөнгөөс гаргуулна.”, 53.3 дахь хэсгийн “Гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн эхний ээлжинд бэлэн мөнгө, эсхүл банк, банкны бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа төлбөр төлөгчийн мөнгөн хөрөнгө болон бусад үнэт зүйлээс төлбөрийг гаргуулна.”, 53.6 дахь хэсгийн “Энэ хуулийн 53.1 дэх хэсэгт заасан эд хөрөнгө байхгүй, эсхүл төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн өмчлөлийн бусад эд хөрөнгөөс төлбөрийг гаргуулна.”, 53.7 дахь хэсгийн “Энэ хуулийн 53.3, 53.6 дахь хэсэгт заасан эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй байвал төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг гаргуулна.” гэснийг тус тус үндэслэн төлбөр төлөгч-иргэнээс төлбөрийг гаргуулна. Төлбөр төлөгчийн дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд ногдох хэсгээс төлбөрийг тооцож гаргуулахдаа Иргэний хуулийг баримтлах юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дээрх заалтуудаас өөр үндэслэлээр төлбөр төлөгч-иргэний болон түүний гэр бүлийн гишүүнээс төлбөр гаргуулахгүй бөгөөд тус хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтын “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас”-ыг төлбөрт хураан авч болохгүй гэсэн нь гэм буруутны ял зэмлэлийг гэр бүлийн гишүүнд халдаан хэрэглэж байгаа асуудал биш юм. Уг заалтад дурдсан асуудлыг эрүүгийн ял гэж үзэхээс илүүтэйгээр төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглосон хэм, хэмжээ тогтоосон заалт гэж үзэж байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйлд “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй” гэж заасан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан эд хөрөнгө нь төлбөр төлөгч-иргэний өөрийн болон гэр бүлийн зайлшгүй шаардлагатай, анхдагч хэрэглээг хангасан эд хөрөнгө байх бөгөөд эдгээрийг төлбөрт хураан авч болохгүй гэж заасан нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дээрх заалтад нийцсэн гэж үзэж байна.

Дээр дурдсаныг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтын “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас”-ыг төлбөрт



хураан авч болохгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтыг зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр уламжилж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх заалтад зөвхөн “Төлбөр төлөгч-иргэн”-ий зайлшгүй хэрэгцээт дараахь эд хөрөнгийг төлбөрт хураан авч болохгүй гэж хуульчилсан атал уг хэсгийн 55.1.2 дахь заалтад “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас” гэж зааж төлбөр төлөгч-иргэнээс гадна түүний гэр бүлийн гишүүдийн хувцаснаас төлбөр гаргуулахаар тусгасан байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан “... Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;” гэсэнд харшилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтын “төлбөр төлөгч болон түүний гэр бүлийн гишүүний улирал бүрийн нэг ээлжийн хувцас;” гэж заасны “... болон түүний гэр бүлийн гишүүний ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “... Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;” гэснийг зөрчсөн байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 дахь заалтын “... болон түүний гэр бүлийн гишүүний ...” гэсэн хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.



3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

**П.ОЧИРБАТ
Т.ЛХАГВАА
Ш.ЦОГТОО
Д.ГАНЗОРИГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: tugiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 9

Индекс: 14003